



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 5/11

Улаанбаатар хот

Хорлооновын Соёл-Эрдэнийг
албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 491 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн Соёлын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн "Нэр дэвшүүлж, санал болгох тухай" 09 дүгээр тогтоол, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 1-10/236 дугаар албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2022 оны "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 01/6144 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хорлооновын Соёл-Эрдэнэ нь Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн тул уг албан тушаалд 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Х.Соёл-Эрдэнийн үндсэн цалинг төрийн захиргааны албан тушаалын ТЗ-4 зэрэглэл 1,088,657 (нэг сая наян найман мянга зургаан зуун тавин долоо) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, тус байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хоол, унааны зардлыг томилогдсон өдрөөс сар бүр бодож олгохыг ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Х.Соёл-Эрдэнэд эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

САЙД



Ч.НОМИН

14190016246



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

С.Тулаа

2023.08.22

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/290

Улаанбаатар хот

**Төрийн захиргааны зарим албан хаагчдад
зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.3, 2.4, 2.5, 2.6, Төрийн албаны зөвлөлийн Соёлын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын сарын 07-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны зарим албан хаагчдад хавсралтад зааснаар албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосугай.

2. Зэрэг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингаас нь тооцож, 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс сар бүр олгохыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Энх-Амгалан), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Мөнхзул) нарт зөвшөөрсүгэй.

САЙД



Ч.НОМИН

Бүртгэл нөмөр: 142
Х

23 09 22
Б.Гыбг

14190016701

		хариуцсан мэргэжилтэн	ахлах		
--	--	--------------------------	-------	--	--

2. Доор дурдсан албан хаагчдад төрийн захиргааны дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр олгосугай.

№	Төрийн албан хаагчийн нэр	Албан тушаалын ангилал		Шинээр олгож буй зэрэг дэв	Зэрэг дэвийн нэмэгдэл (хувиар)
		Эрхэлж буй албан тушаал	Албан тушаалын зэрэглэл		
1	2	3	4	9	10
1	Хорлооновын Соёл-Эрдэнэ	Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын дарга	Т3-4	Ахлах түшмэл, дөтгөөр зэрэг	26



МОНГОЛ УЛСЫН
СОЁЛЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 6/13

Улаанбаатар хот

Хоролноровын Соёл-Эрдэнийг
ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 1-10/236 дугаар албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 01/6144 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хорлооновын Соёл-Эрдэнийг 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрөөс Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын дарга томилогдох хүртэлх хугацаагаар тус албан тушаалд түр томилсугай.

2. Х.Соёл-Эрдэнийн үндсэн цалинг төрийн захиргааны албан тушаалын ТЗ-10 шатлал 3-д хамааруулан 981742 (есөн зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин хоёр) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, тус байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хоол, унааны зардлыг томилогдсон өдрөөс сар бүр олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Х.Соёл-Эрдэнэд эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

САЙД



Ч.НОМИН

14190010362